

СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДЭД УРАН ЗОХИОЛЫГ УНШИЖ, ТАНИЛЦУУЛАХ АРГА, ТЕХНИК

Ц.Наранцэцэг, дэд профессор
МУБИС-ийн БС-ийн СӨБСС-ийн арга зүйн тэнхимийн багш

Abstract: As other forms of art, literature is an important factor for child development. A child starts to completely perceive the plots in literature at the age of 4 to 5 years. Sometimes children have difficulties in understanding fairy tales, proverbs, and riddles because their imagination is not well developed. One of the important roles of a kindergarten is to introduce a child to literature. Literature choice is very important that it should be made relying on children's age and intellectual differences. Children certainly play an important role in understanding the literature but adults as readers make significant contributions too. Their reading and introducing skills directly affects the children's understanding. Preschool teachers use different methods to introduce literature to a child and they have reached to various results. The paper discusses some of the results from our research where we studied and experimented the ways to read and introduce literature to a child.

Түлхүүр үг: Уран зохиол, хүүхэд, уран зохиолтой танилцуулах арга

Удиртгал

Хүн төрөлхтөнг уран зохиолгүйгээр төсөөлөшгүй билээ. Сургуулийн өмнөх насныханд уран зохиол онцгой чухал бөгөөд тоглоом шиг үйлчлэгч байх ёстой. Хүүхэд сонирхсон зохиолоо сонсоод бодож, сэтгэж, мэдэрч, ярьж сурч байдаг гэж эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн байдаг (Алексеева, Яшина, 1998, х.256). Уран зохиолтой танилцсанаар хүүхэд сургуульд бэлтгэгдэж,

танин мэдэхүй, нийгэмшихүй, харилцааны гэх мэт олон талын чадвар нь хөгжинө. “Багш уран зохиолыг танилцуулахдаа оновчтой аргыг сонгох нь чухал бөгөөд хүүхдийн тогтоох, сэргээн санах, эргүүлэн ярих чадвар нь илүү эрчимтэй хөгждөг болохыг судлаачид баталсан байна” (Сохин, 2002, х.182).

Орчин үеийн багш сурган хүмүүжүүлэгч нар цаг үетэйгээ хөл нийлүүлэн алхаж, сургалтын арга зүйгээ байнга дээшлүүлж байх шаардлага чухлаар тавигдаж байгаа билээ. Уран зохиолыг ойлгож, хүртэх нь хувь хүүхдээс шалтгаалах боловч зохиолыг танилцуулж, уншиж өгч байгаа насанд хүрэгчдийн арга барилаас шууд шалтгаалдаг. Багш нар зохиолыг танилцуулах олон төрлийн аргыг хэрэглэж байгаа боловч хүүхдэд буух үр дүн нь өөр өөр байна. Уран зохиолыг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан бүтээлчээр унших технологи, арга зүйг турших үүднээс бид энэ сэдвийг судлах болсон юм.

Хүүхдэд уран зохиолыг бүтээлчээр унших арга, техник

М.Горький хүүхдийн зохиолын гол шаардлагыг “Хүүхэдтэй зугаатай ярих нь чухал” гэж тодорхойлсон байдаг. “Цэцэрлэгийн хүүхдэд уран зохиолыг танилцуулах ажлын зорилгыг өнөө үед дараах байдлаар тодорхойлж байна” (Наранцэцэг, 2007, х.124). Үүнд:

- Уран зохиолыг сонсоод утгыг ойлгох төдийгүй, үйл явдалд нь санаа сэтгэлээ бүрэн чиглүүлэн, зохиолчийн бодол



- санааг хүртэл ойлгодог болох,
- Зохиолд гарч байгаа зүйлүүдийг хүүхэд амьдралын бодит үнэн зүйлүүдтэй харьцуулан хувийн дүгнэлт хийж сурах,
- Сургуульд орох үедээ зохиолын гол баатруудыг тодорхойлон дүгнэж чаддаг, юуны тухай зохиол болох, гол баатар нь илүү таалагдаж байгааг тайлбарладаг, зохиолын хэлбэрийг тодорхойлдог (яруу найраг, өгүүлэл, үлгэр)
- Уншсан зүйлийн дагуу асуулт асуух, асуултанд хариулах, номын зургийг анхааралтай ажиглан уншсан зүйлийн утгатай харьцуулдаг болох
- Хүүхдийг номонд дур сонирхолтой болгох, зохиолоос олж авсан сэтгэгдлээ бусадтай хуваалцдаг болгон төлөвшүүлэх явдал юм.

Хүүхдэд уран зохиолыг танилцуулах олон арга байдгаас хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь урнаар унших арга юм. Мөн уг зохиолын утга агуулгыг алдагдуулахгүйгээр товчлон урнаар өгүүлэн ярьж өгөх арга байдаг. Зохиолыг сонирхолтой болгох аргын нэг нь жүжигчлэн үзүүлэх, ширээний театр, хүүхэлдэй, сүүдэр жүжгийн тоглолтоор үзүүлэх зэрэг аргууд бий. Зарим үед бага хэмжээний зохиолыг цээжлүүлэх аргыг хэрэглэнэ. Давтан унших, түүвэрлэн унших ба нэмэгдэл арга барил болох жүжигчлэлийн элемент оруулах, гар хурууны хөдөлгөөнөөр тоглож үзүүлэх зэргийг хамтатгаснаар зохиолыг сайтар ойлгуулах, сэтгэлийг нь хөдөлгөх ач холбогдолтой.

ОХУ-ын эрдэмтдийн боловсруулсан “Хүүхдийн цэцэрлэг-2100” хөтөлбөрт зохиолыг бүтээлчээр уншиж танилцуулах сонирхолтой арга технологийг тусгажээ (Чиндилова, 2012, х. 189). Сургуулийн өмнөх насны хүүхдийн зохиолыг хүртэх, ойлгох онцлог нь уншиж өгч байгаа насанд хүрэгчдийн унших арга, техникээс ихээхэн шалтгаална. Багш сурган хүмүүжүүлэгчид зохиолыг уншихдаа тодорхой хэсэгт зогсолт хийх, дүрслэн бодох хугацаа өгөх, гүнзгийрүүлэн ухаж ойлгоход нь сэтгэл

хөдлөл болон бусад зүйлээр хүчилж дэмжих гэх мэт энгийн мөртлөө сонирхолтой олон арга техникийг маш тодорхой тусгасан байна.

Ярих үйл ажиллагааны нэг төрөл болох эхийг сонсоод эргүүлэн ярих нь түүнийг хүртэж хүлээж авах, уншиж байгаа зүйлийн агуулгыг дүрслэн бодох, хариу үйлдэл үзүүлэх, сэтгэл хөдлөлтэй хандахаас хамаарах бөгөөд үүнийгээ Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт, Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт унших–сонсох гэж тусгасан байдаг. “Хүүхдийн цэцэрлэг 2100” хөтөлбөрт “Бүтээлчээр унших технологи гэдэг нь эхийг бүрэн хэмжээгээр хүртэж ойлгосны үндсэн дээр зохиогчийн байр сууринаас идэвх санаачлагатайгаар сонсогчдод хүргэхийг хэлнэ” гэж томъёолсон байна. Энэ уншлага нь 3 үе шатыг дамжина гэж үзсэн байна. Үүнд:

- Уншихын өмнө эхтэй танилцах (Сэдвээс тухайн эхийн тухай урьдчилан төсөөлөх, таамаглах, зохиогчийн нэрийг танилцуулах, номын зургийг үзүүлэх зэрэг уншлагын үндсэн чадварыг хөгжүүлэх)
- Унших үед эхтэй ажиллах (Унших, уншлагын тайлбар хийх, эхийг ойлгох орчин бүрдүүлэх, эхийг хүртэх нөхцөлийг хангах, тодорхой хэсэгт зогсолт хийх, дүрслэн бодох хугацаа өгөх, гүнзгийрүүлэн ухаж ойлгоход нь сэтгэл хөдлөл болон бусад зүйлээр хүчлэн дэмжих).
- Уншиж дууссаны эцэст эхтэй ажиллах (зохиогчийн дэвшүүлсэн санааг уншигчийн үүднээс тайлбарлах, тодруулах, эхийн утга санааг гүнзгийрүүлэн ойлгох, дүрслэн бодох нөхцөлийг хангах, багш эхийн талаар асуулт тавих, ярилцлага өрнүүлэх, багш зохиогчийн тухай ярих гэх мэт)

Мөн уран зохиолтой танилцуулсны эцэст зохиолын гарчгийг дахин хэлж, номын зургийг эргэн нэг ажиглана. Зохиолын гол утга санаа, сэтгэл хөдлөлийг хүчтэй гаргасан хэсгүүдийг тодорхойлсон дасгал даалгаврыг хийж гүйцэтгэнэ.

Дээр дурдсан арга зүйг бид туршиж үзэхээр хяналтын болон туршилтын цэцэрлэгийг сонгон авч судалгаа хийж үзсэн юм.

Хүүхдэд уран зохиолыг танилцуулах бүтээлч арга техникийг туршсан судалгааны явц, үр дүн

Бидний судалгааны ажлын зорилго сургуулийн өмнөх насны хүүхдэд уран зохиолыг танилцуулах аргыг харьцуулан бүтээлчээр унших арга, техникийг туршихад оршино.


Судалгааны ажлын хүрээнд хүүхдийн цэцэрлэгийн багш нар уран зохиолтой танилцуулах ямар арга барилыг үйл ажиллагаандаа өргөн хэрэглэдэг болохыг тандах зорилгоор асуулга боловсруулан хот, хөдөөгийн 32 багшийг хамруулан судалгааг авлаа. Байдлыг тогтоох судалгааны үр дүнг нь нэгтгэн үзвэл:

1. Уран зохиолтой танилцуулах үйл ажиллагааг улиралд хэдэн удаа төлөвлөдөг вэ?

Бүдүүвч 1

Долоо хоногт уншиж танилцуулах зохиолын тоо

■ Багшийн тоо



Судалгаанд хамрагдсан багш нарын нэг улиралд хүүхдийг уран зохиолтой танилцуулах үйл ажиллагааны тоо өөр өөр байв. Энэ нь тухайн цэцэрлэгийн хөтөлбөр, багшийн үйл ажиллагааны төлөвлөлттэй холбоотойгоор ялгаатай байгаа нь ажиглагдаж байна. Судалгаанд хамрагдсан багш нарын 23% нь буюу 4 багш долоо хоногт 4 – 6 удаа оруулахаар төлөвлөдөг болох нь судалгааны дүнгээс харагдаж байна. Цэцэрлэгийн насанд хүүхэд үлгэр зохиол сонсох асар их сонирхолтой байдаг. Судалгаанд хамрагдсан багш нарын хариултаас харахад энэ үйл ажиллагаа хэт цөөн явагдаж байна гэж дүгнэж болохоор байна.

2. Уран зохиолыг ямар аргаар танилцуулдаг вэ?

Судалгаанд хамрагдсан багш нар ерөнхийдөө уран зохиолтой танилцуулахдаа унших, харилцан ярилцах аргыг түлхүү хэрэглэдэг гэсэн дүн гарсан байна.

Бүдүүвч 2

Уран зохиолыг танилцуулах арга






Судалгаанд хамрагдсан багш нарын 75% нь урнаар уншиж өгөх аргыг түлхүү хэрэглэдэг гэсэн үр дүн гарсан байна. Судалгааны энэ хэсэгт бид багш бүтээлчээр унших арга технологийн талаар ямар түвшний мэдлэгтэй болохыг тодорхойлох зорилго тавьсан бөгөөд энэ талаар төдийлөн мэдээлэлгүй болох нь ажиглагдлаа.

3. Хүүхдийн анхаарал сарних үед ямар арга хэрэглэдэг вэ? гэсэн асуултанд нэрээр нь дууддаг гэсэн хариултыг судалгаанд хамрагдсан багш нарын 75% нь өгчээ.


Бүдүүвч 3



Унших, уншлагын тайлбар хийх, эхийг ойлгох орчин бүрдүүлэх, эхийг хүртэх нөхцөлийг хангах, тодорхой хэсэгт зогсолт хийх, дүрслэн бодох хугацаа өгөх, гүнзгийрүүлэн ухаж ойлгоход нь сэтгэл хөдлөл болон бусад зүйлээр хүчлэн дэмжих гэх мэт бүтээлчээр уншиж хүүхдийн анхаарлыг төвлөрүүлэх талаар багш нар төдийлөн мэдэхгүй ийм аргыг хэрэглэдэггүй болох нь судалгааны дүнгээс харагдаж байна.

4. Шинэ үгийг хэдийд нь тайлбарладаг вэ?

Бүдүүвч 4



Багш нар ихэнхдээ уншлагын эхэн ба төгсгөл үед нь шинэ үгийг тайлбарлаж өгдөг байна.

Шинэ үгийн тайлбарлах нь уран зохиолтой танилцуулах үйл ажиллагааны чухал хэсэг байдаг. Уншлагын аль үед нь шинэ үг танилцуулахаас хүүхдийн анхаарал төвлөрөх, сарних нь хамаарна. Зохиолыг уран яруу уншиж танилцуулж байгаа үед гэнэт зогсолт хийж шинэ үг танилцуулах нь төдийлөн оновчтой байдаггүй. Судалгаанд хамрагдсан багш нарын 15,6% нь тухайн үед шинэ үг тайлбарлаж өгдөг гэсэн байна.

Уламжлалт аргаар зохиолыг уншиж, танилцуулсны дараа хүүхдүүд зохиолыг хэрхэн ойлгож, ойлгоноо илэрхийлэн ярьж байгааг үнэлж үзлээ.

Судалгаанд 20 хүүхэд хамрагдсан бөгөөд хүүхдийн сонссон зохиолоо эргүүлэн ярих чадварыг рубрик үнэлгээгээр үнэлсэн юм.

Хүснэгт 1

4 -5 хүртэл настай хүүхдийн сонссон зохиолынхоо агуулгыг ойлгох чадвар



Үнэлгээ	Зохиолыг анхааралтай сонсож, ойлгосноо эхлэл өрнөл, төгсгөлтэй илэрхийлэн ярьж байвал	Зохиолыг сонсоод эхлэл өрнөл төгсгөлийн аль нэг хэсгийг дутуу ярьж байвал	Зохиолыг анхаарал муутай сонсож, ярьж чадахгүй байвал
Зохиолын агуулгыг ойлгох чадвар	Зохиолын агуулгыг бүрэн ойлгосон	Агуулгыг дутуу ойлгосон	Тааруу ойлгосон
	4 хүүхэд	5 хүүхэд	11 хүүхэд

Судалгаанаас харахад багш уран зохиолыг унших арга барил техник муутай, уншлагын үед баримтлах арга зүйг төдийлөн эзэмшээгүй байдал ажиглагдаж байлаа. Багш зохиолыг уншихын өмнө бүрэн танилцсан боловч сэдвээс тухайн эхийн тухай урьдчилан төсөөлөх, таамаглах, зохиогчийн нэрийг танилцуулах, номын зургийг үзүүлэх зэрэг уншлагын үндсэн чадварыг хөгжүүлэх зэрэг дээр анхаарлаа хандуулж ажилласангүй. Мөн унших эхийг ойлгох орчин бүрдүүлэх, тодорхой хэсэгт зогсолт хийх зэрэг дээр ахиц байсан боловч, дүрслэн бодох хугацаа өгөх, гүнзгийрүүлэн ухааж ойлгоход нь сэтгэл хөдлөл болон бусад зүйлээр хүчлэн дэмжих тал дээр учир дутагдалтай байв.

Уншиж дууссаны эцэст багш эхийн талаар асуулт тавих, ярилцлага өрнүүлэх зэрэг барилыг хэрэглэсэн боловч багш зохиогчийн тухай ярих, асуултаа оновчтой томъёолох тал дээр алдаа гаргаж байв.

Судалгааны сургах туршилтандаа багш нарт бүтээлчээр унших аргын талаар мэдээллийг өгч сургалт зохион байгуулах тал дээр түлхүү анхаарч ажилласан бөгөөд бүтээлчээр унших технологи болох 3 үе шат бүхий уншлагыг ажлын төлөвлөгөөнд тодорхой тусган зохион байгуулсан юм.

Бүдүүвч 6,7



Сургах туршилтын өмнөх ба дараах үеийн судалгааны үр дүн

Сургах туршилтын явцад багш нарын эзэмшсэн уншлагын арга техник нь хүүхдийг зохиолоо сонсоод ойлгосноо ярих чадварт эерэг нөлөө үзүүлсэн болохыг судалгааны дүн харууллаа.

Судалгаанд оролцсон багш нар хүүхдэд танилцуулах эх зохиолыг сайтар судлан, зохиогчийн нэрийг танилцуулж, номын зургийг үзүүлэн, уншлагын тайлбар хийх зэргээр унших техникт анхаарч ажилласан бөгөөд зохиолын аль хэсгүүд дээр зогсолт хийх, аль хэсэгт сэтгэл хөдлөл, дуу хоолойн өнгийг өөрчлөх гэх мэт энгийн боловч маш нарийн арга техникүүдийг оновчтой хэрэглэснээр ийм үр дүнд хүрлээ гэж бид үзлээ.



ДҮГНЭЛТ

Багш зохиолыг хэрхэн ямар аргаар танилцуулбал хүүхдэд илүү үр дүнтэй байх вэ? гэдгийг алхам бүрээр нь нарийвчлан төлөвлөж ажиллах нь өндөр үр дүнтэй гэж бид үзэж байна. Хүүхдийг уран зохиолтой танилцуулах бүтээлч арга техникийн аргачлал, алхамууд нь энгийн боловч багш бүр суралцахад хялбар арга юм.

Багш зохиолыг уншиж танилцуулахаас өмнө зохиолыг өөрөө уншиж тогтоох, цээжлэх, уран яруу уншлагад бэлтгэх, орчин бүрдүүлэх, зохиолтой холбоотой зураг үзүүлэн бэлтгэх, номын буланг бэлтгэх, хүүхэлдэй, сэдэвт болон сургах тоглоом зэрэг сурах үйлийн хэлбэрүүдийг ашиглахаар зохион байгуулах нь чухал байна.

Манай багш нарын дунд хүүхдийг уран зохиолтой танилцуулахдаа номоо урьдчилан төдийлөн сайн судлахгүйгээр уншиж өгөх, унших бэлтгэлээ хангахгүй байх хандлага түгээмэл ажиглагдаж байна. Багш зохиолыг оновчтой, үр дүнтэй танилцуулахаас хүүхэд багаасаа номонд дуртай болох, сонссон зохиолоо ярих, бусдын яриаг сонсох зэрэг олон чадварууд хэрхэн яаж хөгжих нь шууд шалтгаална гэж бид үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Алексеева, М.М., Яшина, В.И. (1998). Методика развития речи детей дошкольного возраста. Москва. Издательский центр “Академия”.

Наранцэцэг, Ц. (2007). Сургуулийн өмнөх насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх аргазүй. Улаанбаатар: Мөнхийн Үсэг Групп

Сохин, Ф.А. (2002). Психолого-Педагогические основы развития речи дошкольников. Москва: Издательство НПО “МОДЭК”.

Чиндилова, О.В. (2012). *Детский сад 2100*. Москва. Издательство “Баласс”